

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

## ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД


Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааны 14 дүгээр тэмдэглэлд:

“XI.1. 2016 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав:

1. иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг үнэн зөв, тодорхой гаргаж хуульд заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байх;

2. улирал, хагас, бүтэн жилийн тайлан мэдээг Сайдын зөвлөл болон Засаг даргын зөвлөлийн хуралд тус тус танилцуулсны үндсэн дээр Засгийн газарт хүргүүлж байх;

3. өргөдөл гомдлын асуудал хариуцсан албан хаагчдад тусгайлсан сургалт зохион байгуулж ур чадварыг сайжруулах.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР